

**“БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК” ОНӨТҮГ-ЫН
НИЙСЛЭЛИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2019 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН
ЖИЛИЙН ЭЦСИЙН БИЕЛЭЛТ**

2019 оны 12 дугаар сарын 19-ны өдөр

Багануур дүүрэг

| № | Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн заалт | Хэрэгжүүлэх арга хэмжээ | Хариуцах байгууллага | Шалгуур үзүүлэлт | 2019 онд хүрэх түвшин, үр дүн | Шаардлагатай хөрөнгийн хэмжээ /сая.төг/, хөрөнгийн эх үүсвэр | Хэрэгжил-тийн хувь | Үнэлгээ-ний хувь |
|--|--|---|-------------------------|---------------------------------|-------------------------------|--|--------------------|------------------|
| НЭГ. ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ ӨРХ БҮРТ | | | | | | | | |
| 1.1. ҮЙЛДВЭРЛЭЛ, ИННОВАЦИЙГ ЦОГЦООР НЬ ХӨГЖҮҮЛНЭ. | | | | | | | | |
| 1-5 | 1.1.1.4. Багануур дүүрэгт “Багануур үйлдвэрлэл, технологийн парк” байгуулах ажлыг эхлүүлнэ. | “Багануур үйлдвэрлэл, технологийн парк”-ийн дэд бүтцийн ажлыг эхлүүлнэ. | НҮИГ, БҮТП ОНӨТҮГ | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | 30 | Төр хувийн хэвшлийн түншлэл | 25 | |
| | | <p>БХБЯ-ны 2018 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн №2018/10 тоот гэрээгээр Мон-Энержи Консалт ХХК Паркийн Ерөнхий төлөвлөгөө, инженерийн шугам сүлжээний зураг төслийг гүйцэтгэж 2018 оны 09 дүгээр сарын 27-нд дуусах байсан боловч хугацааг 2 удаа сунгаж хойшлуулсан.</p> <p>➤ Паркийн ерөнхий төлөвлөгөөг НИТХ-аар хэлэлцүүлж батлуулсан</p> | | | | | | |

| | | | | | | |
|--|--|---|--|--|--|--|
| | | <ul style="list-style-type: none"> ➤ Цахилгаан хангамжийн техникийн нөхцөл олгогдоогүй ч бусад гадна инженерийн шугам сүлжээний ажлын зураг төсөл боловсруулагдаж БХТ-ийн магадлангаар хянагдаж байна. ➤ Зураг төслийн ажил удааширсан нь цахилгаан хангамжийн техникийн нөхцөл олгогдохгүй байгаагаас болж байна. Шалтгаан нь: <ul style="list-style-type: none"> ○ Эрчим хүчний сайдын 2018 оны 133 дугаар тушаалаар цахилгаан, дулааны техникийн нөхцөл олгохыг 2018 оны 09 дүгээр сарын 25-наас эхлэн 2019 оны 03 дугаар сарын 01-ний өдөр хүртэл түр зогсоох шийдвэр гаргасан. ○ ЭХЯ-ны холбогдох газар нь, БҮТП-ийн ТЭЗҮ-ийг гүйцэтгэгч байгууллага ЭХЯ-ны Шинжлэх ухаан технологийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлээгүй гэсэн шалтгаанаар хойшлуулсан. ○ Мөн горимын ачааллын тооцоог Диспетчерийн үндэсний төв /ДҮТ/-өөр заавал гүйцэтгүүлэх шаардлагатай гэсэн шаардлагыг төсөл гүйцэтгэгч компанид тавьсан. ➤ Паркийн захиргаа уг асуудлыг Эрчим хүчний сайд, Төрийн нарийн бичгийн дарга нарт танилцуулснаар цахилгаан хангамжийн техникийн нөхцөлийг олгох асуудлыг 2019 оны 12 дугаар сарын 03-ны өдөр Эрчим хүчний хэрэгжилтийн Цахилгаан хангамжийн техникийн нөхцөл олгох ажлын хэсгийн хурлаар БХБЯ, БХТ, Мон-Энержи Консалт ХХК, НШУҮИГ, БҮТП-ийн дарга болон холбогдох мэргэжилтнүүдийг оролцуулан хэлэлцэж шийдвэрлэсэн. ➤ Одоо ДҮТ нь төслийн горимын ачааллын тооцоог гаргаж, Мон Энержи ХХК нь цахилгаан хангамжийн техникийн нөхцөлийн дагуу зураг төслийг боловсруулан дуусгаж байна. | | | | |
|--|--|---|--|--|--|--|

| | | | | | |
|--|--|--|--|--|--|
| | | <p>Дэд бүтцийн бүтээн байгуулалтын санхүүжилтийг шийдвэрлэх ажлын хүрээнд дараах арга хэмжээг зохион байгуулав:</p> <ul style="list-style-type: none"> - Дээд шатны 6 байгууллагад санхүүжилтийн асуудлыг тавьж санал хүргүүлсэн. - МУ-ын 2018-2021 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн тодотголд паркийн дэд бүтцийн бүтээн байгуулалтын 161,2 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтыг 2019-2021 онуудад тусгуулахаар ҮХГ-т хүргүүлсэн. - Улс, нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2020 онд хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний саналыг боловсруулж НШУҮИГ, БХБЯ, УУХҮЯ-дад тус тус хүргүүлсэн. - Багануур дүүргийн нийгэм, эдийн засгийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд дэд бүтцийн бүтээн байгуулалтын хөрөнгө оруулалтыг тусгуулахаар саналыг хүргүүлсэн. - МУ-ын дунд болон урт хугацааны зорилтот хөтөлбөр болох Шинэ бүтээн байгуулалтын хөтөлбөрт дэд бүтцийн бүтээн байгуулалтын саналыг хүргүүлэв. - Паркийн зүгээс БХБЯ-нд 2019 оны 06 сард хүнд болон хөнгөн үйлдвэрлэлийн дэд бүтэц, дэд станцын бүтээн байгуулалтын хөрөнгө оруулалтын саналыг боловсруулж хүргүүлэв. - Багануур дүүргээс сонгогдсон УИХ-ын 4 гишүүнд, 2020 онд эхлүүлэх паркийн дэд бүтцийн бүтээн байгуулалтад шаардлагатай хөрөнгө оруулалтын асуудлыг танилцуулж дэмжлэг хүссэн албан бичиг хүргүүлсэн. | | | |
|--|--|--|--|--|--|

| | | | | | | |
|--|---|--|--|--|----|--|
| | <p>- Нийслэлийн нийгэм, эдийн засгийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, НЗД-ын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд 2020 онд хэрэгжүүлэх нийслэлийн өмчийн концессын зүйлийн жагсаалтыг боловсруулж байгаатай холбогдуулан зохих журмын дагуу дэд бүтцийн бүтээн байгуулалтын тооцоолол зураглалыг боловсруулж тус тус хүргүүлсэн.</p> <p>- Хүнд үйлдвэрлэлийн бүсийн 20,1 тэрбум төгрөгийн санхүүжилттэй дэд бүтцийн бүтээн байгуулалтын зардлыг бууруулах, цаг хугацаа хэмнэх үүднээс Багануур ХК-ийн одоогоор ашиглалтгүй байгаа ("Породная станция") төмөр замын хөрс тээвэрлэлтийн станцын барилга байгууламж, дэд бүтцийг ашиглах боломж байгааг судалж, саналаа 2020 оны 1-р улиралд Нийслэлийн Засаг даргын Удирдлагын зөвлөлийн хуралд танилцуулахаар төлөвлөж байна.</p> | | | | | |
| | ДУНДАЖ ХУВЬ | | | | 90 | |



ТАЙЛАН ХЯНАСАН:
 БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭД ТЕХНОЛОГИЙН ПАРК
 ОНӨТҮГ-ЫН ДАРГА *(Signature)* Ч.ЭЛБЭГСАЙХАН

ТАЙЛАН НЭГТГЭСЭН:
 АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН *(Signature)* Б.МИЧИД-ЭРДЭНЭ